МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
**АСУУЛТ**
14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16,
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2019.01.25 № 02

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ
ТАНАА

*Асуулт тавих тухай*

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуултыг тавьж байна.

"Монголиан коппер корпорейшн" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр хувьцаа эзэмшигч Ц.Пүрэвтүвшингийн эзэмшлийн компанийн нийт гаргасан 1.120.010 /нэг сая нэг зуун хорин мянга арван/ ширхэг энгийн хувьцааг бүхэлд нь нэрлэсэн үнээр нь буюу нэг бүрийн 100.000.00 төгрөг, нийт 112.001.000.000.00 төгрөгөөр Сингапур Улсад бүртгэлтэй, 201607637С тоот регистрийн дугаартай "Эрдэнэт Корп Пти.Лтд" компанид аж ахуй нэгжийн хүрээнд худалдан борлуулах шийдвэр гаргасан байна.

"Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн 49 хувийг төрийн мэдэлд авах асуудлыг Монгол Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолоор шийдвэрлэж, Засгийн газар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байгаа билээ.

Иймд УИХ-ын тогтоолыг зөрчиж, Улсын бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагын зүгээс өмчлөлийг шилжүүлэхгүй байх асуудалд болон үүсч байж болзошгүй бусад нөхцөл байдлын талаар нягтлан шалгаж хариу мэдэгдэнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэгт заасны дагуу албан бичгээр ирүүлэхийг Танаас хүсье.

Материалыг хавсаргав. /10 хуу/

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Л.ОЮУН-ЭРДЭНЭ
Т.АЮУРСАЙХАН
Ж.БАТЗАНДАН
Л.БОЛД
Х.НЯМБААТАР

0000000012

MONGOLIAN COPPER CORPORATION

**МОНГОЛИАН КОППЕР КОРПОРЕЙШН ХХК-ИЙН**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШИЙДВЭР**

2019 оны 01 сарын 11 өдөр Дугаар 004-19/02 Улаанбаатар хот

*Хувьцаа худалдах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дахь хэсэг, "Монголиан Коппер Корпорейшн" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн холбогох хэсгийг үндэслэн Хувьцаа эзэмшигчийн хурлаас ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигч Ц.Пүрэвтүвшингийн эзэмшлийн Компанийн нийт гаргасан 1,120,010 *(нэг сая нэг зуун хорин мянга арван)* ширхэг энгийн эрхийн хувьцааг бүхэлд нь нэрлэсэн үнээр нь буюу нэг бүрийн 100,000.00 төгрөг, нийт 112,001,000,000.00 төгрөгөөр Сингапур улсад бүртгэлтэй, 201607637C тоот регистрийн дугаартай "Эрдэнэт Корп Пти. Лтд." компанид худалдсугай.

2. Энэхүү шийдвэрийн дагуу Сингапур улсад бүртгэлтэй, 201607637C тоот регистрийн дугаартай Эрдэнэт Корп Пти. Лтд. компанитай "Хувьцаа худалдах, худалдан авах болон эрх шилжүүлэх гэрээ" байгуулж, Компанийн нийт хувьцаагаар гэрчлэгдэх эрх, үүргийг шилжүүлэхийг хувьцаа эзэмшигч Ц.Пүрэвтүвшинд зөвшөөрсүгэй.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ** **Ц.ПҮРЭВТҮВШИН**

ERDENET CORP
TOWARDS SUSTAINABLE DEVELOPMENT

*Анали хэлнээс орчуулав*

**ERDENET CORP PTE. LTD**
**[ӨМНӨ НЬ MCC PTE. LTD НЭРТЭЙ БАЙСАН]**

**(Компанийн регистрийн дугаар: 201607637C)**
**(Сингапур улсад үүсгэн байгуулагдсан)**
**(цаашид "Компани гэх")**

**КОМПАНИЙН ДҮРМИЙН ДАГУУ БИЧГЭЭР ГАРГАСАН**
**ЦОРЫН ГАНЦ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ШИЙДВЭР**

---

**МОНГОЛИАН КОППЕР**
**КОРПОРЕЙШН ХХК (РД: 5801621)-ИЙН**
**ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ**

**ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Монгол улсад бүртгэлтэй Монголиан Коппер Корпорейшн ХХК-ийн гаргасан 100 хувьтай тэнцэх хувьцааг Худалдан авах гэрээ (цаашид "Хэлцэл" гэх) байгуулан 112,001,000,000.00 төгрөг буюу 41,999,535.00 ам.доллароор худалдан авахыг үүгээр Компанид даалган эрх олгов.

2. Компанийн дангаар хувьцаа эзэмшигч болох Цоож овогтой Пүрэвтүвшин нь Монголиан Коппер Корпорейшн ХХК-ийн мөн цор ганц хувьцаа эзэмшигч болохыг цохон тэмдэглэв.

3. Монголиан Коппер Корпорейшн ХХК-ийн хувьцааны урьдчилгаа төлбөр болох 110,000.00 ам.долларыг шилжүүлэн үлдэгдэл төлбөрийг худалдагч талд дараа төлөх үүргээр компанийн санхүүгийн тайланд бүртгэхийг Компанид даалган эрх олгов.

4. Хэлцэл хийхэд шаардлагатай баримт бичигт компанийн нэрийн өмнөөс гарын үсэг зурах, баталгаажуулах, холбогдох бүхий л ажиллагаанд төлөөлөх бүрэн эрхийг УИ95053161 тоот регистрийн дугаартай Монгол улсын иргэн Батсайхан овогтой НОМИНДАРЬ-д олгов.

5. Компанийн дүрэмд заасны дагуу Хэлцэл хийхэд шаардлагатай баримт бичигт (хэрэгцээт тохиолдолд) Компанийн тамга даран баталгаажуулна.

Огноо: 2019 оны 01 дүгээр сарын 11

[гарын үсэг] [тамга]
ЦООЖ ПҮРЭВТҮВШИН

ММОХХ
TRANSLATION BUREAU
ОРЧУУЛГЫН ТОВЧОО
117

**ХУВЬЦАА ХУДАЛДАХ БОЛОН ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ**

**SHARE SALE AND RIGHTS TRANSFER AGREEMENT**

2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр

№ 19/01

Улаанбаатар хот

Энэхүү **ХУВЬЦАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ БОЛОН ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ** /цаашид "Гэрээ" гэх/-г Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, "Монголиан Коппер Корпорейшн" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2019 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн "Хувьцаа худалдах тухай" шийдвэрийг тус тус үндэслэн,

Pursuant to the Mongolian Civil Code, Company Law of Mongolia, other relevant legislation and Shareholder's resolution of Mongolian Copper Corporation LLC, dated January 11, 2019, this **SHARE SALE AND RIGHTS TRANSFER AGREEMENT** (hereinafter referred to as the "**Agreement**") is made and entered into force by and between:

Нэг талаас Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Баянмонгол хороолол, 412-р байр 164 тоот хаягт байрлах иргэн Цоож овогтой Пүрэвтүвшин /цаашид "**Худалдагч**" гэх/,

Purevtuvshin Tsooj, citizen of Mongolia, whose principal address at #164, apartment 412, Bayanmongol town, Bayanzurkh district, Ulaanbaatar city, Mongolia (hereinafter referred to as the "**Seller**"),

Нөгөө талаас Сингапур улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, 201607637C регистрийн дугаартай "Эрдэнэт Корп Пти. Лтд." компанийг 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Захирлын шийдвэрийн дагуу төлөөлөгч Батсайхан овогтой Номиндарь (РД: УИ95053161), /Цаашид "Худалдан авагч", хамтад нь "Талууд" гэх/ нар харилцан тохиролцож, дараах нөхцөлөөр байгуулав.

"Erdenet Corp Pte. Ltd.", a company incorporated under laws of Singapore, with registration number 201607637C (hereinafter referred to as the "**Buyer**", and together the "**Parties**"), for and on its behalf duly authorized representative by Director's Resolution dated January 11, 2019, Nomindari Batsaikhan (RN: UI95053161), on mutual agreement of both Parties.

## Нэг. Нийтлэг үндэслэл

## One. General Provision

1.1. Худалдагч өөрийн эзэмшдэг "Монголиан Коппер Корпорейшн" ХХК-ийн нэг бүр нь 100,000.00 /нэг зуун мянган/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,120,010 /нэг сая нэг зуун хорин мянга арав/ ширхэг энгийн эрхийн хувьцааг энэхүү гэрээний дагуу бүхэлд нь 112,001,000,000.00 /нэг зуун арван хоёр тэрбум нэг сая/ төгрөг буюу 41,999,535.00 ам.доллараар Худалдан авагчид худалдана.

1.1. According to this Agreement, the Seller shall sell its own 1,120,010 (one million one hundred twenty thousand and ten) common shares with par value o MNT 100,000.00 (one hundred thousand) in th "Mongolian Copper Corporation" LLC, whic represent all issued and paid outstanding shares, fo amount of MNT 112,001,000,000.00 (one hundre twelve billion and one thousand) or US 41,999,535.00 (forty-one million, nine hundred ninet nine thousand, five hundred thirty-five) to the Buyer

1.2. Худалдагч нь гэрээнд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг Худалдан авагчийн нэр

1.2. After transferring the Shares completely to the Buy pursuant to this Agreement, the change in the cap

дээр бүрэн шилжүүлж, холбогдох Монгол Улсын төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлсэнээр Компанийн хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт орсонд тооцно.

1.3. Худалдан авагч нь Хувьцааны үлдэгдэл төлбөрийг 2025 оноос өмнө багтаан бүрэн төлж дуусгана. Үлдэгдэл төлбөрт ямар нэгэн хүү тооцохгүй.

**Хоёр. Худалдагчийн эрх, үүрэг**

2.1. Худалдагч нь дараах үүрэгтэй:

2.1.1. Хувьцааг харилцан тохиролцсон хугацаанд Худалдан авагчийн нэр дээр шилжүүлэх;

2.1.2. Хувьцаа эзэмшигчийн бүтцэд орсон өөрчлөлтийг холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх.

2.2. Худалдагч нь дараахь эрхтэй:

2.2.1. Худалдан авагчаас үүргээ биелүүлэхийг шаардах;

2.2.2. Энэхүү гэрээний 5.1 дэх хэсэгт заасан хувьцааны үнийн урьдчилгаа төлбөрийг төлсний дараа төрийн эрх бүхий байгууллагад шаардлагатай бүртгэлийг хийлгэх.

**Гурав. Худалдан авагчийн эрх, үүрэг**

3. Худалдан авагч нь дараах үүрэгтэй:

3.1.1. Худалдан авсан энгийн эрхийн хувьцааны үнийг Гэрээнд заасан журмын дагуу төлөх;

3.1.2. Энэхүү гэрээний дагуу Худалдагч талаас шилжүүлж буй баримт бичгийг цаг тухай бүрт нь хүлээн авч, бүрэн бүтэн хариуцан хадгалах.

3.2. Худалдан авагч нь дараах эрхтэй:

3.2.1. Худалдагчаас энэхүү Гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;

3.2.2. Хувьцаа шилжүүлэхтэй холбоотой бүх бичиг баримтыг нэн даруй хүргүүлж өгөхийг шаардах Худалдагчаас.

**Дөрөв. Эрх шилжих тухай**

4.1. Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болж, урьдчилгаа төлбөр төлөгдсөнөөр Худалдан

structure of the Company shall become effective by registering it at the competent State authority of Mongolia.

1.3. The Buyer shall pay remaining amount of the Purchase price in before end of 2025. The remaining amount of the Purchase price shall not bear any interest.

**Two. Rights and obligations of the Seller**

2.1 Obligations of the Seller:

2.1.1. Transfer the Shares to the Buyer within mutually agreed period;

2.1.2. Register the amendment made in the Shareholder's structure at the competent State authority.

2.2. Rights of the Seller:

2.2.1. Demand from the Buyer to perform its obligations pursuant to this Agreement.

2.2.2. Register the related amendment to the competent State authority once the Buyer has paid the advanced payment of the share price pursuant to article 5.1 of this Agreement.

**Three. Rights and obligations of the Buyer**

3.1. Obligations of the Buyer:

3.1.1. To pay the purchased common share price pursuant to the terms of this Agreement;

3.1.2. Duly receive the official documents transferred from the Seller in a timely manner, and safeguard those Documents pursuant to this Agreement.

3.2. Rights of the Buyer:

3.2.1. Demand the Seller to perform its obligations pursuant to this Agreement;

3.2.2. Demand from the Seller to promptly deliver of all the relevant official documents related to the transfer of the Shares.

**Four. Transfer of rights**

4.1. As this Agreement becomes effective and advanced payment has paid, it is deemed that the Buyer shall receive

авагч нь хувьцааг өмчлөх, захиран зарцуулах болон түүнд ноогдох хуульд заасан бүхий л эрх, үүргийг шилжүүлэн авсанд тооцно.

4.2. Худалдагч нь Гэрээний дагуу хувьцаа эзэмших эрх болон тэрхүү хувьцаагаар баталгаажсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус бүх эрх, хууль ёсны ашиг сонирхол буюу хувьцааны эрхийг аливаа гуравдагч этгээдийн ашиг сонирхлоос ангид Худалдан авагчид бүрэн шилжүүлнэ.

4.3. Худалдан авагч нь Гэрээний 4.1-д заасны дагуу хувьцаа эзэмших эрхийг хүлээн авснаас хойш Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон хувьцаа эзэмшигчийн эрхийг эдэлнэ.

4.4. Хувьцааг Худалдан авагчийн нэр дээр шилжүүлж Монгол Улсын хуулийн этгээдийн бүртгэлийн газар бүртгэл хийгдсэнээр энэхүү гэрээ бүрэн хэрэгжсэнд тооцно.

all the ownership rights of the Shares and all the obligations related to ownership of the shares, in accordance with the law.

4.2. The Seller shall transfer the share ownership rights, and other property and non-property rights that certified by the such shares, its legal interest and all rights related to it to the Buyer without demand and interest from the third party.

4.3. Once the Buyer has received share ownership and its related rights pursuant to article 4.1 of the Agreement, the Buyer shall be entitled to shareholder's rights which provided by the Company code of Mongolia, and Charter of the Company.

4.4. This Agreement shall complete upon registry of the share transfer in the name of the Buyer with Legal entity registration office of Mongolia.

## Тав. Төлбөр хийгдэх нөхцөл

5.1 Талууд гэрээнд гарын үсэг зурсаны дараа Худалдан авагч тал гэрээний урьдчилгаа төлбөр болох 110,000.00 ам.долларыг Худалдагч талын Монголын Худалдаа, хөгжлийн банкны 499177911 дугаар бүхий дансанд шилжүүлэх буюу бэлнээр төлнө.

5.2 Худалдан авагч тал гэрээний урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэний дараа Худалдагч тал шаардлагатай бүртгэлийг төрийн эрх бүхий байгууллагад хийлгэн, Компанийн хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт оруулна.

5.3 Худалдан авагч тал нь үлдэгдэл төлбөрийг энэхүү Гэрээний 5.1 дэх заалтад тусгасан Худалдагч талын дансанд төлөх бөгөөд энэ тухай Худалдан авагч тал өөрийн санхүүгийн тайланд дараа төлөх үүргээр бүртгэн тэмдэглэнэ.

## Five. Payment Condition

5.1. As both Parties sign and the Agreement becomes effective, The Buyer shall pay an advanced payment of USD 110,000.00 to the Seller's account at Trade and Development bank of Mongolia with number 499177911 by means of cash or non-cash.

5.2. After the Buyer's transaction of the advanced payment the Seller shall submit the relevant registration at the competent state authority and make alteration in the Company's Shareholder structure.

5.3. The remaining amount of the payment shall be paid to the Seller's bank account stated in article 5.1 of this Agreement and shall be recorded and noted in the Buyer's financial statement as payable liability.

## Зургаа. Баталгаа

6.1 Худалдагч нь Худалдан авагчид дараах баталгааг олгоно:

6.1.1 Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр бусад этгээдийн өмнө хариуцан төлөх,

## Six. Representations and warranties

6.1. The Seller represents and warrants to the Buyer the followings:

6.1.1 By the date of this Agreement becoming effective, the Shares are free and clear of any direct or

ACRA

ACCOUNTING AND CORPORATE REGULATORY AUTHORITY

# CERTIFICATE CONFIRMING INCORPORATION OF COMPANY

| | | |
|---|---|---|
| Company Name | : | ERDENET CORP PTE. LTD. (name change effective from 12/10/2018) |
| UEN | : | 201607637C |

This is to confirm that the company was incorporated under the Companies Act, on and from 23/03/2016 and that the company is a EXEMPT PRIVATE COMPANY LIMITED BY SHARES.

The company was formerly known as:

| S/N | Company Name | Effective From |
|---|---|---|
| 1 | MCG PTE. LTD. | 12/10/2018 |

(Note: Only the five (5) most recent former names are listed. Any change in company name effected before 13 Jan 2003 will not be listed)

REGISTRAR OF COMPANIES & BUSINESS NAMES ★ ACRA

TAN YONG TAT
ASST REGISTRAR OF COMPANIES & BUSINESS NAMES
ACCOUNTING AND CORPORATE REGULATORY AUTHORITY
SINGAPORE

Dated : 12/10/2018
Receipt Number : ACRA181012156175

ERDENET CORP PTE. LTD.
UEN No.: 201607637C

Authentication No. : K18732294E

# АКРА

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ БОЛОН КОМПАНИ

## ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА

## КОМПАНИЙН БҮРТГЭЛ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

**Компанийн нэр: ERDENET CORP PRE. LTD. (2018.10.12-нд нэр өөрчлөгдсөн)**

**Хуулийн этгээдийн дугаар: 201607637С**

Компани нь 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдөр "Хувьцаагаар хязгаарлагдах хувийн компанийн хэлбэр"-ээр Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан болохыг энэхүү гэрчилгээгээр баталгаажуулж байна.

Компанийн өмнөх мэдээлэл:

| **Компанийн нэр** | **Хүчинтэй байсан хугацаа** |
|---|---|
| 1. MCC PTE.LTD. | 2018.10.12 |

(Мэдээлэл: Зөвхөн хамгийн сүүлд хийгдсэн 5 өөрчлөлт бичигдэнэ. 2003 оны 01 дүгээр сарын 13-наас өмнө хийгдсэн өөрчлөлт бичигдэхгүй болно.)

[гарын үсэг] [тамга]

ТАН ЁОНГ ТАТ

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ БОЛОН КОМПАНИ ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН КОМПАНИ БОЛОН БИЗНЕСИЙН НЭР БҮРТГЭГЧ

Огноо: 2018/10/12

Хүлээн авсан дугаар: ACRA181012156175

Хувьцаа эзэмшигчийн 2019 оны
01 дүгээр сарын 14-ний өдрийн
ХЭШ-19/03 тоот тогтоолын хавсралт 1

## МОНГОЛИАН КОППЕР КОРПОРЕЙШН ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ
(Шинэчилсэн найруулга)

### НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

1.1. **МОНГОЛИАН КОППЕР КОРПОРЕЙШН ХХК ("Компани")** нь Монгол Улсын Иргэний хууль (**"Иргэний хууль"**), Монгол Улсын Компанийн тухай хууль (**"Компанийн тухай хууль"**) болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах ба энэхүү дүрэм ("Дүрэм")-ийн хүрээнд ашгийн төлөө бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

### ХОЁР. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ХАЯГ, ЭРХ ХЭМЖЭЭ

2.1. Компанийн оноосон нэрийг

- Монгол хэлээр "МОНГОЛИАН КОППЕР КОРПОРЕЙШН" ХХК
- Англи хэлээр "MONGOLIAN COPPER CORPORATION" LLC

2.2. Компанийн оршин байгаа газрын хаяг:

Улсын нэр: **МОНГОЛ УЛС**
Нийслэлийн нэр: **УЛААНБААТАР ХОТ**
Дүүргийн нэр: **СҮХБААТАР ДҮҮРЭГ**
Хороо, хороололлын нэр: **1-Р ХОРОО, ЭНХТАЙВНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ 17**
Байшин, хаалганы дугаар: **БЛЮ СКАЙ ТАУЭР, 5-Р ДАВХАР, 501 ТООТ**
Мэйл хаяг: info@mcc.mn

2.3. Компанийн салбар болон төв байр нь тус бүрийн хаягтай байна.

2.4. Компани нь өөрийн тэмдэг, барааны тэмдэгтэй байх бөгөөд түүний загварыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) эсхүл Гүйцэтгэх захирал батална.

2.5. Компани нь өөрийн тамга, бэлгэдэл болон хууль ёсны хаяг бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Хэвлэмэл хуудсыг загварыг ТУЗ эсхүл Гүйцэтгэх захирал батална.

2.6. Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаандаа холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлж, тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

Appendix 1 of Shareholder's resolution
No. 19/03 of January 14, 2019

## COMPANY CHARTER OF "MONGOLIAN COPPER CORPORATION" LIMITED LIABILITY COMPANY
/Revised version/

### ONE. GENERAL PROVISION

1.1. **MONGOLIAN COPPER CORPORATION LLC** (herein after as "Company") is the limited liability company which conducted business activities for profit in accordance with this charter, Civil code of Mongolia (herein after as "Civil code"), Company law of Mongolia (herein after as "Company law") and other related legislation.

### TWO. COMPANY NAME AND ADDRESS

2.1. Company name:

- Mongolian: "МОНГОЛИАН КОППЕР КОРПОРЕЙШН" ХХК
- English: "MONGOLIAN COPPER CORPORATION" LLC

2.2. Permanent address of the Company:

State name: **MONGOLIA**
Capital: **ULAANBAATAR**
District: **SUKHBAATAR DISTRICT**
Sub district, town: **1ST SUB DISTRICT, PEACE AVENUE 17**
Building, door: **BLUE SKY TOWER, 5TH FLOOR, #501**
Mail address: info@mcc.mn

2.3. Any branch and headquarters of the Company shall have its own address.

2.4. The Company shall have own symbol and trademark and its design shall be approved by the Company's Board of Directors (BOD) or Executive Director.

2.5. Company shall use letterhead with its own seal, symbols and permanent address of the company. Letterhead design shall be approved by BOD or Executive director.

2.6. Company shall conduct business operations which requires specific profession and license, once obtaining licenses issued by a competent state

2.7 Компани нь улсын бүртгэлд орсон өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөрт тооцогдоно.

## ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХЛЭХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

3.1. Компани нь холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрсөн дараах ажил, үйлчилгээг эрхэлнэ:

(a) Гадаад худалдаа;
(b) Уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа;
(c) Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх;
(d) Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;
(e) Бизнесийн зөвлөгөө өгөх;
(f) Менежментийн зөвлөгөө өгөх;
(g) Хүнд машин механизмийн тоног төхөөрөмжийн худалдаа;
(h) Гэрээгээр өрөмдлөг хийх;
(i) Геологийн тойм судалгаа хийх;

3.2. Компани нь Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг хугацаагүйгээр явуулна.

## ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

4.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь Компанийн нийт гаргасан болон эргэлтэнд оруулсан хувьцаанаас ("Хувь нийлүүлсэн хөрөнгө") бүрдэх бөгөөд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд зарласан боловч гаргаагүй болон халаасны хувьцаа хамаарахгүй (тухайлбал Компанийн эргүүлэн худалдаж авсан хувьцаа).

4.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүр нь 100,000 (зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,120,010 (нэг сая нэг зуун хорин мянга арван) ширхэг энгийн эрхийн хувьцаа ("Хувьцаа")-тай байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн нийт хэмжээ нь 112,001,000,000 (нэг зуун арван хоёр тэрбум нэг сая) төгрөг байна.

4.3. Компаний дүрмийг бүртгүүлэх өдрийн байдлаар Компанийн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцаа нь дараах хүснэгтэнд тусгагдсанаар байна. Үүнд:

| № | Хувьцаа эзэмшигч | Гаргасан хувьцаа | | Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| | | Тоо ширхэг | Нийт үнэ /төгрөгөөр/ | |
| 1 | Эрдэнэт корп ПТИ. ЛТД (РД: 201607637C) | 1,120,010 | 112,001,000,000 | 100% |
| Total | | | 112,001,000,000 | 100% |

authority by law, and registering operation at the State registration office.

2.7. Amendment to state registration of the company shall be deemed as valid, once company has registered amendment within term that provided by related legislation.

## THREE. BUSSINESS OPERATION AND SERVICE OF THE COMPANY, ITS SCOPE

3.1. Company shall conduct following operations and service according to related legislation:

(a) Foreign trade;
(b) Mining equipment trade;
(c) Mining consulting;
(d) Project development;
(e) Business consulting;
(f) Management consulting;
(g) Machinery equipment trade;
(h) Drilling service by contract;
(i) Geological broad research.

3.2. Company shall conduct business operation which provided provision 3.1 of this Charter with unlimited term

## FOUR. SHARE CAPITAL OF THE COMPANY

4.1. Share capital of the company shall consist with total issued and outstanding shares (referred as "share capital") of the Company, shares that authorized but not issued and redeemed premium shares (such as: redemption of shares by the company) shall not considered as share capital.

4.2. Share capital of the Company shall consist with total 1,120,010 (one million one hundred twenty thousand and ten) common shares with par value of 100,000 (one hundred thousand) MNT and total share capital of the Company is 112,001,000,000 (one hundred twelve billion and one thousand) MNT.

4.3. Shareholder of the company shall own following shares by the registered date of the company's charter.

| No | Share holder | Issued shares | | Percentage On |
|---|---|---|---|---|
| | | Shares | Total /MNT/ | |
| 1 | Erdenet corp Pld. Ltd. (Registration No. 201607637C) | 1,120,010 | 112,001,000,000 | 100% |
| Total | | | 112,001,000,000 | 100% |